



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 729

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Усны газрын харьяа Сав газрын захиргаадын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 16 нэрийн нийт 134,674,007.80 (нэг зуун гучин дөрвөн сая зургаан зуун далан дөрвөн мянга долоон төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Усны газрын дарга Ш.Мягмар, Сав газрын захиргаадын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132007540

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
229 дугаар тогтоолын хавсралт

**УСНЫ ГАЗРЫН ХАРЬЯА САВ ГАЗРЫН ЗАХИРГААДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1. Идэр голын сав газрын захиргаа						
1	Зөөврийн компьютер	12.31.2014	ш	1	1,581,470.00	1,581,470.00
2	Мотоцикль	12.31.2014	ш	1	1,790,250.00	1,790,250.00
	Хэсгийн дүн			2	3,371,720.00	3,371,720.00
2. Туул голын сав газрын захиргаа						
3	Таблет /Samsung/	2016	ш	1	550,000.00	550,000.00
4	Принтер /HP-MFP-M130FN/	2016	ш	2	649,900.00	1,299,800.00
5	Хөрсний чийг хэмжигч багажны ком	2016	ш	68	410,704.56	27,927,910.08
6	Компьютер	2016	ш	2	837,500.00	1,675,000.00
7	Принтер HP-MFP M225	2016	ш	2	699,900.00	1,399,800.00
8	Мэдээ хуримтлуулагч багаж	2016	ш	30	717,135.20	21,514,056.00
9	Бороо хэмжигч, агаарын температур хэмжигч	2016	ш	17	833,150.71	14,163,562.07
10	Агаарын даралт хэмжигч логгер	2016	ш	2	620,490.00	1,240,980.00
11	Гадаргын усны түвшин хэмжигч логгер	2016	ш	4	620,490.00	2,481,960.00
12	Логгероос мэдээ авагч залгуурын ком	2016	ш	3	441,985.00	1,325,955.00
13	Мониторингийн хэмжилтийн багаж /логгер/	2016	ш	61	719,925.65	43,915,464.65
14	Хөлдөлт, гэсгээлтээс хамгаалах багаж /кабель/	2016	ш	6	2,000,000.00	12,000,000.00
15	Сейф	2011	ш	2	710,000.00	1,420,000.00
16	Бичгийн ширээ	2011	ш	2	193,900.00	387,800.00
	Хэсгийн дүн		ш	202	10,005,081.12	131,302,287.80
НИЙТ ДҮН				204		134,674,007.80
						(нэг зуун гучин дөрвөн сая зургаан зуун далан дөрвөн мянга долоон төгрөг наян мөнгө)